Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Хэрэгжүүлсэн хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин Биелэлт | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **НЭГ. “Салбарын хууль тогтоомж, эрх зүйн бусад актын төсөл боловсруулах, хууль зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1 | Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллах | Боловсруулсан хуулийн төсөл болон холбогдох баримт бичгийн бүрдэл | 40% | Яамдуудаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | Монгол Улсын Улсын их хурал, Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. | I-IV улиралд | 80% |
| 2 | Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллах | Боловсруулсан хуулийн төсөл болон холбогдох баримт бичгийн бүрдэл | 5% | 100% Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | Монгол Улсын Улсын их хурал, Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. | I-IV улирал | 80% |

114

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Яамны албан хаагчдад хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх, тушаал, холбогдох шийдвэрийн төслийн эрх зүйн үндэслэлийг хянах, зөвлөгөө, санал өгөх | Тушаал, холбогдох шийдвэрийн төсөлд хууль эрх зүйн зөвлөгөө өгсөн тоо | 0% | Яамны албан хаагчид хууль, эрх зүйн мэдээлэл болон мэргэжил, арга зүйн туслалцаагаар хангагдсан байна. | Эрүүл мэндийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, албан даалгавар, шийдвэрийн төслийн хууль эрх зүйн үндэслэлийн тогтмол хянж, санал өгч ажилласан. Шаардлагатай эрх зүйн үр дагавартай албан бичиг, харилцаа, гэрээнд мөн эрх зүйн дэмжлэг тогтмол өгч байна. | I-IV улиралд | 100% |
| **ХОЁР. "Салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, тайлагнах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** ***/Албан тушаалын зорилго, зорилтод суурилсан ТЖАХ-ийн гүйцэтгэлийн зорилт/*** | | | | | | | |
| 1 | Монгол Улсын нэгдэн орсон эрүүл мэндийн салбарын чиг үүрэгт хамаарах олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийг нэгтгэн, хугацаанд нь тайлагнах, хяналт тавих | Холбогдох байгууллагад хүргүүлсэн тайлан | 0% | Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийг тайлагнасан байна. | Монгол Улсын нэгдэн орсон эрүүл мэндийн салбарын чиг үүрэгт хамаарах 10 гаруй олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнасан. | I-IV улиралд | 100% |
| 2 | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланг Засгийн газарт хүргүүлэх | Засгийн газарт хүргүүлсэн тайлан | 0% | Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна. | Эрүүл мэндийн яам болон эрүүл мэндийн салбарт гаргасан өргөдөл гомдлын тайланг нэгтгэн гаргаж улирал тутам Засгийн газарт тайланг хүргүүлж ажилласан. | I-IV улиралд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Салбарын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэн гаргах | Хугацаанд нь тайлагнасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан | 0% | Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд нь Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн байна. | Салбарын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг бусад харьяалах газар, хэлтсээс нэгтгэн гаргаж сар бүрийн эхний 5 хоногт багтаан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. | I-IV улирал | 100% |
| 4 | Эрүүл мэндийн яамны болон харьяа байгууллагуудын ХАСХОМ мэдүүлэгчийн 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд нь баталгаажуулах ажлыг зохион байгуулж, тайланг АТГ-т хүргүүлэх | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргасан албан хаагчдын хувь | 100% | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд бүрэн гаргуулсан байна. | Эрүүл мэндийн яамны болон харьяа байгууллагуудын ХАСХОМ мэдүүлэгчийн 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугцаанд нь гарган баталгаажуулсан. Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран ажилладаг ТББ-дын Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг 2024 оноос эхлэн мэдүүлж эхэлсэн. | I улиралд | 100% |
| 5 | Эрүүл мэндийн яам түүний харьяа байгууллагын Авлигаас | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 0% | Төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлын жилийн | Эрүүл мэндийн салбарын авлигын эсрэг 2024 оны үйл | | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн байгууллагуудыг арга зүйгээр хангаж ажиллах | | | эцсийн тайланг АТГ-т хүргүүлсэн байна. | ажиллагааны батлагдсан төлөвлөгөөг Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн чиглэлийн дагуу 7 дугаар сард шинэчилэн 5 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, харьяа байгууллагуудад хүргүүлж биелэлтийн хангуулсан. Эрүүгийн цагдаагийн албатай хамтран ЭМЯ, УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-II, СЭМҮТ, ХТС, ГҮТ, АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлгийн албан хаагчдад "Эрүүл мэндийн салбарт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цаашид анхаарах асуудал" сэдвээр 2024 оны 01-03 дугаар сард сургалт зохион байгуулж, нийт 1000 гаруй албан хаагч оролцсон. | I-IV улиралд | |

17

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн асуудлаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн байгууллагуудыг арга зүйгээр хангаж ажиллах | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 0% | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээс Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв болон Өмнөговь аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Өргөө амаржих газартай холбоотойгоор 3 зөвлөмжийг ирүүлсэн. Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг тухай бүр албан бичгээр хуулийн хугацаанд нь хүргүүлсэн.<br>Хүний эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ХЗДХЯ-наас боловсруулж, Засгийн газрын тогтоолоор батлуулахаар санал авахаар ирүүлсэн бөгөөд ЭМЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд хариуцах асуудлаар хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 1а/1813 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Хүний эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн зөвлөмжүүдийг үндэслэн | III-IV улирал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөө"-г 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Эрүүл мэндийн сайд баталсан. Үүний дагуу эрүүл мэндийн байгууллагуудад төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж, тайланг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр ирүүлэх тухай чиглэлийг хүргүүлсэн. Үүний дагуу харьяа эрүүл мэндийн байгууллагууд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг ирүүлж байна | | |
| **ГУРАВ. "Салбарын хууль тогтоомж, эрх зүйн актын мэдээллийн сан бүрдүүлэх, лавлагаа мэдээллээр үйлчлэх ажлыг удирдан зохион байгуулах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1 | Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг хянах, зөвлөгөө өгөх, улсын бүртгэлд бүртгүүлэх | Улсын бүртгэлд бүртгэгдсэн захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн тоо | 0% | Хууль, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол шийдвэрт нийцсэн байх ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн байна. | Захиргааны хэм хэмжээ тогтоосон нийт 8 шийдвэрийн боловсруулалтанд зөвлөгөө, санал өгч, улсын бүртгэлд бүртгүүлсэн. Үүнд:<br>Эрүүл мэндийн сайдын 2024 оны Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журмыг шинэчлэн батлах тухай А/74, | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2024 оны Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний зааврыг батлах тухай А/293, А/133,<br>Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан Жагсаалт батлах тухай А/96, А/104, А/81 дүгээр тушаал,<br>Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2024 оны "Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох журам" А/225/А153/А/86 дугаар тушаал,<br>Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2024 оны " "Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам" А/259/А173/А/94 дүгээр тушаал,<br>Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн | | |

180

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сайдын хамтарсан Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журам А/178, А/238, А/173 дугаар тушаал,<br>Цусны байнгын болон амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журам А/207 дугаар тушаалыг улсын бүртгэлд бүртгүүлсэн. | | |
| 2 | Яам, Засгийн газрын агентлагаас батлан гаргасан захиргааны хэм хэмжээний актуудын уялдааг хангах, давхардал зөрчлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх | Дүн шинжилгээ хийсэн захиргааны хэм хэмжээний актуудын тоон мэдээлэл бүхий тайлан | 0% | Санал дүгнэлт бүхий тайланг ХЗДХЯ-нд хүргүүлсэн байна | Хууль зүйн яаман дээр байгуулагдсан Захиргааны хэм хэмжээний актын давхардлыг арилгах, уялдааг хангах ажлын хэсэгт Бодлого төлөвлөлтийн газартай хамтран ажиллаж санал боловсруулсан. | IV улирал | 100% |
| 3 | Дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнтэй байгуулсан гэрээний мэдээний сан үүсгэх, баяжилт хийх | Тогтмол баяжилт хийсэн гэрээний мэдээний сан | 0% | Гэрээний цахим сан үүсгэж, тогтмол баяжилт хийсэн байна. | Эрүүл мэндийн яамтай байгуулсан дотоодын аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнтэй байгуулсан гэрээнд тухай бүр дугаар олгож, цаасан хэлбэрээр буюу гэрээний бүртгэлийн дэвтэрийг хөтөлж, гэрээний мэдээний санд тогтмол баяжилт хийж ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 161 гэрээг бүртгэсэн. | I-IV улирал | 100% |

15

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Гэрээний цахим сан үүсгэх хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмжийг захиалсан бөгөөд нийт байгуулагдсан 161 гэрээг бүртгэхээр төлөвлөн ажиллаж байна. Гэрээний цахим сан үүсгэхэд шаардлагатай Сканнерийг 2024 оны эхний улиралд захиалахаар хүсэлт өгсөн ч байгууллагын төсвийн асуудлын улмаас хүлээгдсэн тул одоогоор цахим сан үүсээгүй байна. | | |
| **ДӨРӨВ. “Хэлтсийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, зохицуулалт” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** ***/Албан тушаалын зорилго, зорилтод суурилсан ТЖАХ-ийн гүйцэтгэлийн зорилт/*** | | | | | | | |
| 1 | Хэлтсийн албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлүүлэхэд хяналт тавьж ажиллах | Хугацаанд нь шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл гомдлын тоо | 0 | Албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэхэд байнгын хяналт тавьж арга зүйгээр хангаж ажиллаж байна. 2024 оны 12 сарын байдлаар эцэслэн шийдвэрлээгүй, хаагаагүй албан бичиг, өргөдөл гомдол байхгүй байна. | I-IV улирал | 100% |
| 2 | Сайд, Дэд сайд, ТНБД, харьяа газрын даргаас өгсөн чиг үүрэгтэй холбоотой шуурхай | Нэмэлтээр өгсөн шуурхай үүрэг даалгаварын тоо | 0 | Нэмэлтээр өгсөн үүрэг даалгаварыг хугацаанд нь | Эрүүл мэндийн сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн захиргааны удирдлагын газрын даргаас өгсөн чиг | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэхэд хяналт тавих | | | гүйцэтгэсэн байна. | үүрэгтэй холбоотой шуурхай үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэх болон гүйцэтгэхэд хяналт тавьж байна. Хугацаа хоцроосон үүрэг даалгавар байхгүй байна. | | |
| 3 | Эрх зүйн маргаанд олгосон итгэмжлэлийн дагуу Эрүүл мэндийн яамыг төлөөлж оролцох | - Яамыг төлөөлөн оролцсон эрх зүйн маргааны тоо<br>- Шийдвэрлэгдсэн маргааны тоо | 0 | Шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй маргаанд оролцсон байна. | Төрийн захиргааны удирдлагын газрын хуулийн хэлтэс 2024 оны байдлаар 33 эрх зүйн маргаанд оролцсож шийдвэрлэсэн байна. | II-IV улирал | 100% |
| 4 | Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, шийдвэрлэлтэд байнгын хяналт тавих, арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулах | Албан хэрэг хөтлөлттэй холбоотой гарсан зөрчлийн тоо | 0 | Яамны албан хэрэг хөтлөлт стандартын дагуу явагдсан байна. | Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, шийдвэрлэлтэд байнгын хяналт тавих, арга зүйгээр хангаж ажиллаж байна. 2024 оны 12 сарын байдлаар эцэслэн шийдвэрлээгүй, хаагаагүй албан бичиг, өргөдөл гомдол байхгүй байна. | I-IV улирал | 100% |
| 5 | Яамны төрийн нууцтай холбоотой үйл ажиллагааг хууль журмын хүрээнд зохион байгуулах | Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн зөрчлийн тоо | 0 | Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж хэрэгжсэн байна. | Нууцын журмаар ирсэн, явсан албан бичгийн бүртгэлийг хөтөлж, холбогдох албан тушаалтанд танилцуулах, бүртгэлийн дугаар олгох, холбогдох байгууллагад хүргэж өгөх ажлыг хийж гүйцэтгэсэн. Ирсэн нууц, | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | маш нууц албан бичгүүдийн шийдвэрлэлтийн хугацаанд хяналт тавьж ажилласан ба 100 % шийдвэрлэгдэж хариу өгөгдсөн.<br>Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийн яамны 2023 онд хийсэн ажлын тайланг Тагнуулын Ерөнхий газарт нууцын журмаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Нууц баримт бичигтэй танилцах эрх бүхий Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга, Нийтийн эрүүл мэндийн газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар ажиллаж байсан албан хаагчдын шилуилт хөдөлгөөнийг ТЕГ-рт энэ оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн 2/4491 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.<br>Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Эх,нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II, ХСҮТ, Герентологийн үндэсний төв, Нийгмийн эрүүл | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэндийн үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд "Хууль хэрэгжүүлэх тухай" 11 сарын 05-ны өдрийн 2/4529 дүгээр албан бичгийг хүргүүлэв.<br>Дээрх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлснээр төрийн болон албаны нууцыг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нууц албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулж хэрэгжүүлсэн нь Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж хэрэгжиж байна. | | |

**ТАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/д | Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Хэрэгжүүлсэн хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Гүйцэтгэл | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | |
| 1 | Шинээр гарсан хууль тогтоомжийг тухай бүр судалж, албан хэрэгцээнд ашиглах | Судалж, албан хэрэгцээнд ашигласан хууль тогтоомжийн тоо | 0 | 5-аас доошгүй хууль тогтоомжийг судалсан байна. | Эрүүл мэндийн тухай хууль, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тухай | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хууль, Эрүүгийн хууль зэрэг хуулийг судалсан байна. | | |
| 2 | ЭМЯ-ны Харьяа байгууллагуудын хууль эрхзүйн асуудал хариуцсан ажилтнуудад сургалт зохион байгуулах | Зохион байгуулсан сургалтын тоо | 0 | Сургалтыг нэг удаа зохион байгуулсан байна. | ЭМЯ-ны Харьяа байгууллагуудын хууль эрхзүйн асуудал хариуцсан ажилтнууд, төрийн бус байгууллага, нийгэмлэг холбоодын асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд эрх зүйн сургалтыг 4 удаа зохион байгуулсан. | I-IV улирал | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ......................................... /Б.ОДГЭРЭЛ/ 2024 оны 12 дугаар сарын 06

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо)*